

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАЙЛАН
/Есөнзүйл сум/**

2022.12.28

Мөнхбулаг

Өвөрхангай аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх заалтуудыг сумын Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, сумын тухайн оны хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган биелэлтийг тооцон ажиллаж байна.

Өвөрхангай аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Хүний хөгжил, Эдийн засаг, Засаглалын бодлого, Ногоон хөгжил, аялал жуулчлал, Ковид-19 гэсэн нийт 5 бүлгийн суманд хамаарал бүхий заалтуудын хүрээнд биелэлтийг нь тооцон ажиллаж байна. Хүний хөгжлийн бүлгийн нийт 17 зорилт 29 арга хэмжээнээс 100%-тай биелсэн 14 арга хэмжээ, 90%-тай биелсэн 10 арга хэмжээ, 70%-тай биелсэн 1 арга хэмжээ, 50%-тай биелсэн 1 арга хэмжээ, 30%-тай биелсэн 2 арга хэмжээ байгаад бөгөөд тус бүлэг нь 84,4%-ийн биелэлттэй хэрэгжсэн. Засаглалын бодлого бүлгийн нийт 6 зорилт 11 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 8, 90%-ийн биелэлттэй 2, 70%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ байгаа бөгөөд тус бүлэг 95,4%-ийн биелэлттэй хэрэгжсэн. Эдийн засаг бүлгийн 6 зорилт 13 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 6 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 5 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ байгаа бөгөөд тус бүлэг 90%-ийн биелэлттэй хэрэгжсэн байна. Ногоон хөгжил, аялал жуулчлал бүлгийн 2 зорилт 4 арга хэмжээнээс 90%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ байгаа бөгөөд тус бүлэг 90%-ийн биелэлттэй хэрэгжсэн байна. Ковид-19 бүлгийн нийт 2 зорилт 4 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 2, 90%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ байгаа бөгөөд тус бүлэг 95%-ийн биелэлттэй хэрэгжсэн байна. Өвөрхангай аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт нийт 33 зорилтийн 59 арга хэмжээ нийт 91,4 хувийн биелэлттэй хэрэгжээд байна.

Өвөрхангай аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнөөс суманд амжилттай хэрэгжиж байгаа зарим онцлог ажлуудыг товч байдлаар авч үзлээ. Үүнд:

Сурлагын хоцрогдлыг арилгах төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу танхим болон цахим сургалтыг хослуулан зохион байгуулж ирсэн бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилээс бүгд танхимаар хичээллэж байна. Энэ хугацаанд мэргэжлийн багш нар цахим хичээл боловсруулж medle.mn сайтад байршуулахын сацуу уг сайтад тавигдсан хичээлүүдээс авч сургалтандаа ашиглаж байна. Тус сургуулийн мэргэжлийн багш нар нь өөрсдийн бэлтгэсэн цахим хичээлийн сантай бөгөөд теле хичээл болон бусад мэргэжлийн багш нарын бэлтгэсэн цахим хичээлүүдийн санг бүрдүүлж гэнэтийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд хүүхэд Цар тахлын үед 4 бүлгийн эцэг эх асран хамгаалагчидтай Бүлгийн групп чат нааж тухайн группээрээ цахим хичээлүүдийг бэлтгэн тавих, үлгэр, шүлэгийг нь цахим болгож хүүхдэд сонирхолтой эцэг, эхчүүдэд хүүхдэд заахад дөхөмтэй байхаар бэлтгэж өгч байсан. Мөн боломжтой үед нь гэрээр

даалгавар боловсруулж тарааж өгч үр дүнг тооцож ажилласан. Нийт 2 удаагийн давтамжтай 70 гаруй хүүхдэд дасгал ажлын ном, дуу шүлэг, дүрслэх урлах урлан бүтээх нийт 230 гаруй ном бэлтгэж өгсөн. Цахим хичээлээс гадна дасгал даалгавар өгч биеэр хийлгэх нь үр дүнтэй байсан.

“Миний нутаг сайхан” спортын уралдааны анхан шатны шалгаруулалтыг сумандаа зохион байгуулж ажиллалаа. Анхан шатны шалгаруулалтад нийт 115 иргэн идэвхтэй хамрагдаад байна. “Миний нутаг сайхан” спортын наадмын сүүлийн шатанд сумаас Шатар, Софт волейбол, ширээний теннис, бөхийн нийт 4 төрөлд 11 иргэн оролцлоо. Шатарын эрэгтэй төрөлд 4 дүгээр байрт шалгарч амжилттай оролцоод ирсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлого 530450.0 мян/төгрөгийг санд төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 130 хувь байна. Албан журмын орлого 473194.5 мян/төгрөг цуглуулж, төлөвлөгөөг 200 хувиар биелүүлсэн байна. Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого 95255.4 мян/төг, төлөвлөгөөний биелэлт 50 хувьтай байна. Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн дагуу даатгуулагчдын шимтгэл, хураамжийн орлого 121708.0 мян/төгрөг цуглуулж, орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлж ажиллалаа. Үүнээс хураамжийн орлого 21707.7 мян/төг, орлогын төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна. Шимтгэлийн орлого 100001.0 мян/төг, орлогын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна

2022 оны хувьд Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 2022 оны 1 хоршоо, 3 аж ахуй нэгж, 18-н иргэний төсөл “Төсөл сонгон шалгаруулах хороогоор” хэлэлцэгдсэнээс 1 хоршоо, 3 аж ахуй нэгж, 10 иргэний төсөл тэнцэж үнэлгээний хороонд хүргүүлж ажиллалаа. Хоршоо хөгжүүлэх сангаас 150 сая төгрөгийн санхүүжилтээр сумын тэргүүлэх чиглэлийн хүрээнд

1. Эсгий үйлдвэрлэл : 1 Хоршоо
2. Авто машин засвар үйлчилгээ: 1 ААН
Хоршоо-1
3. Бууз, банш, хэрчсэн гурилын цех :1 ААН
ААН-3
4. Зочид буудал, цайны газар: 1 ААН
Иргэн-10
5. Сүү, Цагаан идээ боловсруулах : 4 иргэн
6. Мах, дайвар бүтээгдэхүүн: 1 иргэн
7. Гутал, монгол гутал үйлдвэрлэл: 2 иргэн
8. Хэрчсэн гурил үйлдвэрлэл: 1 иргэн
9. Оёдол: 1 иргэн
10. Нэхмэл шүүр: 1 иргэний

төслийг сонгон шалгаруулж 1 хоршоо, 3 ААН, 10 иргэний төслийг дэмжин сум орон нутагтаа ажлын байр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлж ажиллалаа

Emongolia цахим систем болон иргэдэд шууд хүрч үйлчлэх нийт 90 үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар emongolia цахим системээс нийт 70 иргэнд, 100 гаруй иргэнд хууль эрх зүй болон шүүхийн талаарх мэдээ мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажилласан байна. Мөн хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр нийт 10 гаруй сэдвийн хүрээнд цахим хаягаар мэдээллийг хүргэн 1500 иргэний хандалт аван ажиллаж байна. Мөн 8 сэдвийн хүрээнд гарын авлага боловсруулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Мөн суманд эд хөрөнгийн бүртгэлийн улсын бүртгэлийн эрх 2022 оны 02 дугаар сараас эхлэн нээгдэж Барьцаалбарын гэрээний бүртгэл 2, худалдах худалдан авах гэрээний бүртгэл 12, өөрт ноогдох хэсгээ бусдад бэлэглэх гэрээ 7, барьцаалбар дуусгавар болгох бүртгэл 21, Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 2, эд хөрөнгийн үнэ, хэмжээ гүйцэтгэл өөрчлөгдөх 14, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 2, нийт 62 бүртгэлийг жилийн эцсийн байдлаар хийгээд байна. Суманд эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ нээгдснээр иргэд тус үйлчилгээг газар дээрээс нь түргэн шуурхай авч чадаж байна.

ХЯНАСАН, ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА  Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН БИЧСЭН:
ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Т.МӨНХЗУЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЕСӨНЗҮЙЛ СУМ



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

МӨНХБУЛАГ
2022 он

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/ЕСӨНЗҮЙЛ СУМ/**

2022.12.23

Мөнхбулаг

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээ	30 хувь	50 хувь	70 хувь	90 хувь	100 хувь	Арга нэгдсэн хувь	хэмжээний
1	Хүний хөгжил	17	29	2	1	1	10	14		88.4
2	Эдийн Засаг	6	13	-	1	1	5	6		90
3	Засаглалын бодлого	6	11	-	-	1	2	8		95.4
4	Ногоон хөгжил, аялал жуулчлал	2	3	-	-	-	3	-		90
5	Ковид 19	2	4	-	-	-	2	2		95
	Нийт	33	59	2	2	3	22	30		91.4

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА  Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН БИЧСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Т.МӨНХЗУЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
/ЕСӨНЗҮЙЛ СУМ/

2022.12.22

Мөнхбулаг

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				Он	Түвшин		
НЭГ.ХҮНИЙ ХӨГЖИЛ							
Зорилго: Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, гэр бүлд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй цогц бодлого хэрэгжүүлнэ							
ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ							
Зорилт.1.1. Эх хэл, соёл ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, гэр бүлд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй цогц бодлого хэрэгжүүлнэ.							
1	Биет бус өвийг өвлөн уламжлуулах шавь сургалтыг хөгжүүлж, шилдэг өвлөн уламжлагчдыг дамжин төв халхын болон нутгийн онцлогтой өвийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.	28 сая	Урамшуулсан дэмжсэн өвлөн уламжлагчийн тоо	2021	18	5	Соёлын биет бус өвийг өвлүүлэн уламжлагч иргэнийг цахим системд бүртгэжүүлэх улсын тооллогын ажлыг хийж нас барсан 2 иргэний мэдээлэлийг бүртгэлээс хасч, шинээр Т.Нарангэрэл (уртын дуу), Б.Бат-Эрдэнэ (уртын дуу) гэсэн 2 өвлөн уламжлагчийг шинээр бүртгэлээ. Ардын авъяастан М.Сугарыг (Ардын дууны) төрлөөр онцлон Соёлын төвийн цахим хуудсанд байршуулан, алдаршуулж хойч үедээ түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Угийн бичиг хөтлүүлэх ажлын хэсгийг дахин сургалтанд хамруулж номын санч мэдээлэлийн ажилтан Н.Мөнхнасан албан байгууллагуудад угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг хувиарийн дагуу зохион байгуулж байна. Энэ хүрээнд ажлын хэсгийн гишүүд угийн бичгээ бүрэн хөтлөсөн. Соёлын төвийн хамт олон 2021 онд угийн бичгээ бүрэн хөтөлсөн бөгөөд төрөл садны судалгаагаа хийж угийн бичгээ баяжуулж байна. Сумын хэмжээнд угийн бичиг хөтлөх ажил бага зэрэг үр дүн муутай иргэд болон төрийн албан хаагчид хойрго хандаж байгаа. Нийт иргэдийн дунд угийн бичиг хөтлөлтийн түвшин 20%-тай байна. Биелэлт:90%

2	Өндөр Гэгээний соёлын өвийг сурталчлах, соёлын өвийг сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор “Zanabazar Art festival” урлагийн олон улсын наадмыг зохион байгуулна	-	Урлагийн олон улсын наадмыг зохион байгуулсан эсэх	2021	Урлагын наадмыг зохион байгуулж 230 уран бүтээлч оролцсон	Урлагийн наадмыг зохион байгуулсан байна.	“ӨНДӨР ГЭГЭЭНИЙ СОЁЛЫН ӨВ-2021” арга хэмжээ нь 2021 оны 07 дугаар сарын 28 дугаар аас 08 сарын 01-ний хооронд Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Улаанчулуудад амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү “Занабазар арт фестиваль” арга хэмжээг Өвөрхангай Аймгийн Засаг Даргын Тамгын Газар, Өвөрхангай Аймгийн Боловсрол Соёл Урлагийн Газар, Өвөрхангай Аймгийн Есөнзүйл сум, Занабазарын Нэрэмжит Дүрслэх Урлагийн Музей, Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн, SENGERRAGI Mongolian Art Gallery зэрэг зургаан байгууллагууд хамтран зохион байгууллаа. Дэмжигч байгууллагуудаар Хурд Хамтлаг, Chuba Design, Таван Нүдэн Mongolian Brand, Монгол Саха Нийгэмлэг, Гэгээн Тал Групп, Монголын Үндэсний Телевиз, Гэрэл зургийн GAMMA агентлэг, Сүлд телевиз, Pro Artist Studio, UVLIVE.MN, Соёлын өв хөгжлийн дархлаа зэрэг байгууллагууд дэмжигч байгууллагаар оролцов. Олон улсын арт фестивальд 13 орны уран бүтээлчдийн 200 орчим бүтээлүүд оролцсоноос уран зураг, монгол зураг, уран дархан-баримал-сийлбэр, уран хатгамал-арьс-эсгий урлаг, орчин үеийн урлаг, өв уламжлагч гэсэн зургаан төрлөөр шилдэг уран бүтээлчдийг тодрууллаа. 2022 оны хувьд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй байна. Биелэлт: 50%
3	Зарим сумдын номын сангуудыг LIBU-IV программаар хангах	6,0 сая төгрөг	Libu-iv дрограммаар хангагдсан номын сангийн тоо	2021	1	18	Өвөрхангай аймгийн Соёл урлагийн газраас шинэ суурин компьютероор хангаж 2022 оны 10 дугаар сард Номын сан нь 330000 төгрөгний “Libu-iv” цахим программтай болоод байна. Биелэлт: 100%
ЭРҮҮЛ МЭНД							
Зорилт.1.2 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн огошилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.							

4	Хавдрын 7 төрөл, даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэг зорилтот насны хүмүүсийг хамруулж, эмчилгээ, хяналтыг зохион байгуулна.	70,0 сая	Эрт илрүүлэгийн хамрагдалтын хувь	2021	42	50	Артерийн даралт, чихрийн шижин-2 хэв шинжит өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж нийт хамрагдвал зохих 804 иргэдийн 82.6%-г хамруулан ажиллалаа. Умайн хүзүүний хавдар илрүүлэх үзлэгт хамрагдвал зохих 150 зорилтот насны эмэгтэйчүүдийн 135 хамруулж 90% байна. Хөхний үзлэгт нийт 508 эмэгтэй хамрагдахаас 483 эмэгтэй хамрагдаж 95% хамрагдсан байна. Биелэлт: 90%
Зорилт.1.5 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлэн, чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.							
5	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн үр дүнг тооцох, цаашдын 2022-2032 оны дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулна.	50,0 сая	Их эмя сувилагчийн харьцааг нэмэгдүүлнэ	2021	1:1:3	1:1:4	MNS5081:2013 Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 сарын 29 өдрийн А/540 тоот тушаал ЭМТ-ийн даргийн 2022 оны 01 дүгээр сарын 01 өдрийн Б/01 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар бүтэц, 2 дугаар хавсралтаар орон тоо, 3 дугаар хавсралтаар ЭМТ-ийн хэвтэн эмчлүүлэх орыг баталсан. Монгол улсын стандарт, эмч аас батлагдсан, одоо ажиллаж байгаа орон тоог харьцуулан үзэхэд хангалт 93%-ийн хангалттай байна. Тэргүүлэх зэрэгтэй сувилагч-1, ахлах зэрэгтэй сувилагч-2, магистр, ахлах зэрэгтэй эх баригч-1 ажиллаж байна. ЭМТ-ийн дарга Ж.Хоролсүрэн эх барих эмэгтэйчүүдийн баримжаа олгох 1 сарын, ЭХО-ний 3 сарын курст суралцсан. Уламжлалтын их эмчээр Б.Өнөрцэцэг төгсөж ирсэн. СМА Э.Цэрэндулам 3 сарын олгох амжилттай төгсөж, одоо дээшлүүлэхэд суралцсан. 2023 онд 2 их эмчийг ЭХО-ний 3 сарын курст суралцуулахаар төлөвлөн ажиллаж байна. Нарийн мэргэжлийн эмчээр үе шаттай хангах 2023 онд дүрс оношилгоо, 2023 онд Лаборант, 2023 онд эрчимт эмчилгээний 3 сарын олгох курс, 2024 онд мэдрэл судлал, 2025 онд хүүхдийн эмч суралцуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2022 онд Энэрэл АУИС, ЭМГ-тай хамтран 4 хүнийг туслах сувилагч мэргэжлээр элсүүлэн суралцуулж байна. Нийгмийн баталгаа хангах зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтэн ирж ажиллах үед байраар хангаж, цахилгааны төлбөр,

							халаалтын зардлыг ЭМТ-ийн төсвөөс ханган ажиллаж байна. Сумын засаг дарга нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэн ирж ажилласан тохиолдолд 3.000.000 сая хүртэл төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр мөрийн хөтөлбөртөө тусган ажиллаж байна. Биелэлт:100%
Зорилт.1.6 Зарим төрөлжсөн төвүүд болон сумдын Эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.							
6	Өлзийт, Есөнзүйл сумдын мооргийн барилга, Хархорин сумын өрхийн эмнэлгийн хуучин байрыг тус тус засварлана.	-	Барилгын ажлын гүйцэтгэлээр	2021	0	100	Төндөр зарлагдсан боловч шалгарах байгууллага олдоогүй. Биелэлт:30%
БИЕИЙН ТАМИР							
Зорилт.1.7. Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх (эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах) нөхцөлийг бүрдүүлж олон нийтэд хүртээмжтэй болгох							
7	Иргэдийн дунд "Миний нутаг сайхан" спортын наадмыг зохион байгуулна	24,1 сая	Иргэдийн дунд наадмыг зохион байгуулсан эсэх	2021	-	Иргэдийн дунд наадмыг зохион байгуулсан байна.	"Миний нутаг сайхан" спортын уралдааны анхан шатны шалгаруулалтыг сумандаа зохион байгуулж ажиллалаа. Анхан шатны шалгаруулалтанд нийт 115 иргэн идэвхтэй хамрагдаад байна. "Миний нутаг сайхан" спортын наадмын сүүлийн шатанд сумаас Шатар, Софт волейбол, ширээний теннис, бөхийн нийт 4 төрөлд 11 иргэн оролцлоо. Шатарын эрэгтэй төрөлд 4 дүгээр байрт шалгарч амжилттай оролцоод ирсэн. Биелэлт:70%
БОЛОВСРОЛ							
Зорилт.1.9. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.							
8	Баян-Өндөр, Нарийнтээл, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Бүрд сумдын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг дотуур байрын ариун цэврийн	-	Ашиглалтад орсон ариун цэврийн байгууламжийн тоогоор	2021	2	5	Эрдэнэт ТӨҮГ-ийн 100,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй бага оврын ариун цэврийн цэвэршүүлэх байгууламжийн төсөл Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн дотуур

	байгууламжуудыг ашиглалтад оруулна.						байрны орчимд газар шорооны ажил эхлэн ажлын явц 30%тай биелээд байна. Биелэлт:30%
Зорилт.1.10. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах барилгуудад их засвар хийнэ.							
9	Сургууль цэцэрлэгийн материаллаг болон нийгэм сэтгэлзүйн орчны эрсдэлийг бууруулах арга хэмжээн зохион байгуулна.	-	Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын эзлэх хувиар	2021	50%	80%	Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нар нь эрсдэлийн үнэлгээг хийн үнэлгээгээр гарсан нийгэм сэтгэлзүйн болон материаллаг эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Биелэлт:90%
Зорилт.1.11. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж боловсролын үйлчилгээний хүртээмжийг хэмэгдүүлнэ							
10	Баруунбаян-Улаан, Баянгол, Баян-Өндөр, Өлзийт, Уянга сумын Жаргалант багийн сургууль, "Физик", Гучин-Ус, Есөнзүйл, Уянга, сумын Жаргалант багийн сургуулт, Хайрхандулаан, Хархорин сумын Номын хүрдэн сургуулиуд –"Хими"-ийн, Бат-Өлзий сумын ЕБС технологийн кабинет, Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын сургуулийг англи хэлний кабинетын тоног төхөөрөмжөөр хангана.	134,0 сая	Кабинетийн тоног төхөөрөмжтэй болсон сургуулийн тоогоор	2021	10	15	Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын сургуульд 2021 онд нийт 16 сая төгрөгөөр иж бүрэн химийн кабинетийг байгуулан хүүхдүүд хичээлийг туршлага, далагаар бүрэн эзэмжих боломж бүрдэн ажиллаж байна. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсанаар нийт 64180,0 төгрөгний англи хэлний лингафоны танхимын техник хэрэгсэл, ширээ сандалуудыг татан авчирч байршуулсан. Биелэлт:100%
11	Богд, Хайрхандулаан, Есөнзүйл, Хужирт, Өлзийт, Баруунбаян-Улаан, Баянгол, Бүрд сумдын Хархорин сумын 1 дүгээр сургууль, номын хүрдэн сургууль, Арвайхээр сумын 1 дүгээр	50,0 сая	Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	2021	70-90	100	Сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд нийт 64 сая төгрөгний 7 хяналтыг камерыг суурилуулан дотуур байрны сурагчдын аюудгүй байдлыг ханган ажиллаж байна. Биелэлт:100%

	сургуулиудын дотуур байруудын хяналтын камерын тоог нэмэгдүүлэх, сайжруулж шинэчилнэ.						
Зорилт.1.12. Боловсролын үйлилгээг чанартай зохион байгуулж сургалтын чанарыг дээшлүүлнэ							
12	Багш, удирдах ажилтны ажлын арга барил, үйл ажиллагааны үр дүн, ур чадварын түвшин тогтоох, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор багш, удирдах ажилтныг аттестатчилах ажлыг үе шаттай зохион байгуулна.	-	Үнэлгээний түвшингээр урамшуулал авах багшийн эзлэх хувиар	2021	0	40-өөс дээш хувь нь урамшуулал авсан байна	Тус сургуулийн заах аргын нэгдлийн хамт олон мэргэжил сурталчлах 21 хоногийн аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааг төлөвлөн төлөвлөгөөний дагуу багш, сурагчийн хөгжлийг дэмжсэн сайн хичээл, судалгаат хичээлүүдийг хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд технологич багш, бүтээлч багш шалгаруулах уралдааныг амжилттай зохион байгуулж ажиллалаж байна. Биелэлт:90%
13	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх арилгах цогц төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн ахицаар	2021	-	Танхимын болон цахим сургалтыг тасралтгүй зохион байгуулсан байна	Сурлагын хоцрогдлыг арилгах төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу танхим болон цахим сургалтыг хослуулан зохион байгуулж ирсэн бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилээс бүгд танхимаар хичээллэж байна. энэ хугацаанд мэргэжлийн багш нар цахим хичээл боловсруулж medle.mn сайтад байршуулахын сацуу уг сайтад тавигдсан хичээлүүдээс авч сургалтандаа ашиглаж байна. Тус сургуулийн мэргэжлийн багш нар нь өөрсдийн бэлтгэсэн цахим хичээлийн сантай бөгөөд теле хичээл болон бусад мэргэжлийн багш нарын бэлтгэсэн цахим хичээлүүдийн санг бүрдүүлж гэнэтийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд хүүхэд Цар тахлын үед 4 бүлгийн эцэг эх асран хамгаалагчидтай Бүлгийн групп чат нааж тухайн группээрээ цахим хичээлүүдийг бэлтгэн тавих, үлгэр, шүлэгийг нь цахим болгож хүүхдэд сонирхолтой эцэг, эхчүүдэд хүүхдэд заахад дөхөмтэй байхаар бэлтгэж өгч байсан.Мөн боломжтой үед нь гэрээр даалгавар боловсруулж тарааж өгч үр дүнг тооцож ажилласан. Нийт 2 удаагийн давтамжтай 70 гаруй хүүхдэд дасгал

							ажлын ном, дуу шүлэг, дүрслэх урлах урлан бүтээх нийт 230 гаруй ном бэлтгэж өгсөн. Цахим хичээлээс гадна дасгал даалгавар өгч биеэр хийлгэх нь үр дүнтэй байсан. Биелэлт:100%
Зорилт.1.13. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил,эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил төлөвшил, хос бичигтэн, хүн төрөлхтний нийтлэг зүйлийг тусган хэрэгжүүлнэ.							
14	Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлж, хос бичигтэн аяны 2 дугаар шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	-	Үндэсний бичгийн сургалтад хамрагдсан, төрийн байгууллага албан хаагчийн тоогоор	2021	41/1386	60/1500	Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиолын 3 багш нийт 100 гаруй төрийн албан хаагчдад 2022 оны 10 сараас эхлэн нэг сарын хугацаанд монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтуудыг хуваарийн дагуу зохион байгуулж төрийн албан хаагчийн монгол бичигийн түвшинг тодорхойлох арга хэмжээг авч ажиллалаа. Биелэлт:90%
Зорилт.1.15. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгох, тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарч ажиллана.							
15	Ерөнхий боловсролын сургуулийн 6,7 настай хүүхдийг дотуур байрын орчинд амьдрах, хичээлийн хоцрогдол арилгах, төлөвшүүлэх чиглэлээр ахмад багш нарын нөөцийг дайчлан хөгжүүлэх загвар гарган, зарим сумдад хэрэгжүүлнэ.	-	Ахмад багшийн тоогоор	2021	0	5	Ерөнхий боловсролын сургуулийн 6,7 настай хүүхдийг дотуур байрын орчинд амьдрах, хичээлийн хоцрогдол арилгах, төлөвшүүлэх чиглэлээр дотуур байрны ахмад багшийг 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулж байна. Биелэлт:90%
16	Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх харилцан туршлага солилцох, багшийн ажлын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор "Чадварлаг багш" арга хэмжээ, "Бүсийн төвий	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгээр	2021	-	Бүсчилсэн сургалт, зөвлөгөөнү үдийг зохион байгуулсан байна.	Тус сургуулийн заах аргын нэгдлийн хамт олон мэргэжил сурталчлах 21 хоногийн аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааг төлөвлөн төлөвлөгөөний дагуу багш, сурагчийн хөгжлийг дэмжсэн сайн хичээл, судалгаат хичээлүүдийг хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд технологич багш, бүтээлч багш

	журам” -ын хэрэгжилтийг ханган ажиллана.						шалгаруулах уралдааныг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Биелэлт:90%
ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ							
Зорилт.1.16. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх замаар гэр бүлийн хөгжлийг дэмжих, тогтвортой чадавхжсан гэр бүлийг төлөвшүүлнэ.							
17	Есөнзүйл суманд хүүхдийн хөдөлмөр зусланг байгуулах ажлыг эхлүүлнэ	Орон нутгийн төсөв	Зуслан байгуулах	2021	-	Зуслангийн ажлыг эхлүүлсэн байна.	Хөдөлмөр зуслан байгуулах төсөв шийдэгдээгүйн улмаас ажил эхлээгүй тул хэрэгжилт тооцох боломжгүй ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ
18	Хүүхдийн нөхцөл байдлын судалгааг хийнэ	-	Суурь судалгаа	2021	Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр батлагдсан	Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаарх суурь судалгаатай болсон байна.	Гэр бүлийн хүчирхийлэл бол гэмт хэрэг юм гэсэн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар зорилтот бүлгийн иргэдэд 1 удаа сургалтыг зохион байгуулж мөн боршур, гарын авлага тараан ажилласан. Мөн цахим орчинд гэр бүлийн боловсролыг түгээх ажлыг хийж гүйцэтгэлээ. Зорилтот айл өрхүүдээр нөхцөл байдлын үнэлгээ хийх явцдаа мэдээ, мэдээллийг өгч ажилласан. Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах үйл ажиллагааг тогтмолжуулах хүрээнд 5 дугаар сарын 25-ны өдөр гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх талаар арга зүйн зөвлөгөө чиглэл өгч ажилласан. Энэ хүрээнд хийгдсэн ажлын тайланг Соёлын төв, Эрүүл мэндийн төв ирүүлээд байна. Нийгэмд түгээмэл буй архидан согтуураар гэр бүлийн хүчирхийллийн бууруулах чиглэлээр тус сумын ГХУСАЗСЗ даргат болон багийн засаг даргатай хамтран хариуцсан сумандаа өдөр,орой эргүүлийн үүрэг гүйцэтгэнэ ажиллалаа. Үүрэг гүйцэтгэх хугацаанд Зориулалтын бус газар архидан согтуурсан, олон нийтийн гудамж тайлбайд бие зассан ,хог хаясан болон бусдын амгалан тайван байдлыг алдагуулсан гэх нийт 34 хэв журамын зөрчил илрүүлэн хариуцлага хүлээлгэн ажилласан байна. Биелэлт:90%

19	Залуучуудын хөгжлийн төв байгуулж стандартын дагуу тохижуулж үйл ажиллагааг эхлүүлнэ	10,0 сая	Залуучуудын хөгжлийн төв	2021	Танхим асуудал шийдэгдсэн байна.	Залуучуудын хөгжлийн жишиг болсон байна.	Суманд “Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Төв”-ийг ашиглалтанд оруулж сумын ард иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг нээж зарим танхимуудыг тохижуулан ажлыг эхлүүлж хариуцах иргэдэд нь хүлээлгэн өглөө. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран залуучуудын хөгжлийг дэмжих соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, сайн дурын ажил, санал санаачилгыг дэмжих хүрээнд: Засаг даргын 2022 оны 03 сарын 23-ны өдрийн А/38 дугаартай захирамжаар Залуучуудын хөгжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулж жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Залуучууд хөгжлийн зөвлөлийг 21 гишүүнтэй, дөрвөн багийн дэргэдэх залуучууд хөгжлийн зөвлөлийг 11 гишүүнтэй байгуулан арга зүйгээр ханган сургалт нөлөөллийн ажлыг хийгээд байна. Сумын Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ард иргэд, аж ахуй нэгж, Албан байгууллагуудын дунд “Залуучууд хөгжлийн зөвлөлөөс”-с иргэдийн авъяас ур чадварыг нээн, урлаг спортын зарим төрлийг хөгжүүлэх зорилгоор болейвол, дартс, буухиа, сугалаа, караоке-ний төрлүүдээр тэмцээн уралдаан зохион байгуулж ажиллалаа. “Хүүхэд, Залуучууд хөгжлийн төв”-д Залуучууд хөгжлийн зөвлөл-ийн өрөө гаргуулан уг өрөөг зөвлөлийн гишүүдтэй хамтран тохижуулж ажилсан. Мөн Өвөрхангай Арвайхээр сум Хүүхдийн ордонд зохион байгуулсан сумдын залуучууд хөгжлийн зөвлөлийн чуулга уулзалтад 5 гишүүнийг сургалтад хамруулсан.Залуучуудын үндэсний цахим чуулганд оролцох залуучууд хөгжлийн зөвлөлийн 11 гишүүний мэдээллийг салбарлуу илгээн залуучуудын өмнө тулгамдсан асуудал үндэсний цахим хэлэлцүүлэгт оролцуулан ажиллалаа. Биелэлт: 100
----	--	----------	--------------------------	------	----------------------------------	--	---

20	“Хүүхэд хамгаалал”-ийн хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.	-	Чадавхжуулах сургалтын тоо	2021	Чадавхжуулах сургалт 2	Хамтарсан багийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Сумын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг онлайн сургалтанд 2 удаа хамруулсан. Албан байгууллагууд дэргэдээ “Гэр бүлийн зөвлөл”-ийг байгуулан үйл ажиллагаа тогтмолжин ажиллаж байна. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас байгууллагын гэр бүлийн зөвлөлийн гишүүдэд цахим сургалтыг зохион байгуулж албан байгууллагын гэр бүлийн зөвлөлийн ахлагч нарыг бүрэн хамрууллаа. Албан байгууллага бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, Хүүхэд хамгааллын бодлогыг албан байгууллага бүр хяналтандаа авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Биелэлт:100%
Зорилт.1.17. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тасралтгүй хөгжүүлэх тэдний эрэлт хэрэгцээнд суурилсан, хөгжил, оролцоог хангасан салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.							
21	Ахмад настны аж байдлын судалгааг хийж, судалгаанд үндэслэн шаардлагатай цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	2,2 тэрбум Халамжийн сан	Ахмад настанд нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх	2021	Аймгийн хэмжээнд нийт 11,000 ахмад настан байна.	Судалгаан л хамрагдсан ганц бие болон эрсдэлт нөхцөлд амьдардаг ахмадуудын 10 хувьд хүрч үйлчилсэн байна.	Сумын ахмад настны аж байдлын судалгааг хийж олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлийн төсөлд 2 ахмад настан хамрагдаж хүлэмжинд хүнсний ногоо тариалж ажлын байртай болоод байна. Мөн харьяалалгүй 269 ахмад настанд 2 удаа хүндэтгэл үзүүлсэн. 312 ахмад настанд Насны хишгийн тэтгэмжийг олгоод байна. Биелэлт:90%
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ							
Зорилт.1.20. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.							

22	Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлнэ.	1,5 тэрбум	Шинээр бий болсон ажлын байрын тоо	2021	1102 ажлын байр	2000 иргэн ажлын байраар хангагдсан байна	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, ажилд зуучлах замаар 68 ажлын байр бий болсон. 2022 онд: Шинэ ажлын байр 75 бий болсноос түр ажлын байр 42, байнгын ажлын байр 33 бий болоод байна. Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн сургалтанд хамруулан ажиллалаа. Ажил олгогч байгууллага аж ахуйн нэгжид 7 байнгын ажлын байр, иргэдээс ирсэн захиалгын дагуу 14 ажлын байр, ХЭДС-ийн төсөл хөтөлбөрөөр 10 ажлын байр, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 16 ажлын байр, мод тарих ажилд 15 иргэнийг, төвлөрсөн хогийн цэгийг эмхлэн цэгцлэх хоёрдогч түүхий эд ангилан ялгах нийтийг хамарсан ажилд 13 нийт 75 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангаж ажиллалаа. Биелэлт:100%
23	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн бүртгэл мэдээлэлд тулгуурлан төсөл, хөтөлбөрийг хоновчтой хуваарилан зохион байгуулна.	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2021	Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч иргэдийн судалгааг 18 сумаар гаргасан	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүд зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулна.	Албан бус салбарт ажиллаж буй иргэдийн бүртгэлийг шинэчлэн ажиллаж байна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 1 иргэн, сумын Хоршоо рөгжүүлэх сангаас нийт 8 иргэнд төслүүдийг олгож ажлын байртай болгоод байна. Биелэлт:100%
Зорилт.1.21. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төр, хувийн хэвшлийн байгууллагууд ажилтан, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.							
24	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчилж, сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулсан байна.	2,0 сая	Зохион байгуулсан сургалтын тоо	2021	-	100-аас доошгүй байгууллага сургалт зохион	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар цахим боршур бэлтгэн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон бусад албан байгууллагын цахим хуудсуудад байрлуулан иргэдэд сурталчлан ажиллалаа. Мөн Тахилга, Мөнхбулаг, Хайрхан,

						байгуулсан байна.	Эрээний багуудын Багийн Иргэдийн нийтийн нийт 12 удаагийн хурал дээр цагдаагийн хэсэгтэй хамтран өссөн дүнгээр 350 гаруй иргэдэд мэдээлэл хийн гарын авлага тараан ажиллаад байна. Сумын нийт 5 төрийн байгууллагын албан хаагчдад хөдөлмөрийн тухай хууль болон, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн талаарх мэдээллийг 2 удаагийн танхим сургалтаар хүргэн ажиллалаа. Биелэлт:90%
Зорилт.1.22. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, зорилтот өрх иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.							
25	Халамжаас хөдөлмөрт шилжүүлэх “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамраглал өрхийн тоог бууруулна.	890,1 сая	Хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо хэрэгжүүлсэн арга хэмжээ	2021	Үйлчилгээнд 2653 өрх хамрагдаж байсан	Үйлчилгээнд хамрагддаг өрхийн тоог 10 хүртэлх хувиар бууруулах	2022 оноос хөтөлбөрийн хугацаа хэрэгжиж эхэлсэн. Нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа өрхүүдийн 15-55 насны эмэгтэй 15-60 насны эрэгтэйчүүдийн судалгааг гарган дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилласан. Тус хөтөлбөрт 12 өрхийн 59 иргэн хамрагдаж байгаа бөгөөд эдгээр өрхүүдээр явж өрх бүр дээр нөхцөл байдлын үнэлгээ хийсэн. Мөн өрхийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Нийт 59 иргэнийг насны хувьд авч үзвэл 0-18 насны хүүхэд 24, 18 –аас дээш насны 35 иргэн байгаагаас өндөр насны тэтгэвэр авдаг 4, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авдаг 1, ахмад настан болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа 5 иргэн байна.Хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэдээс хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил хайгчаар 9 иргэн бүртгүүлсэн. 5 иргэн байнгын ажлын байранд, ямаа самнах болон хог ангилан ялгах нийтийг хамарсан ажилд 16 иргэн хамрагдаж түр ажлын байртай болоод байна. Биелэлт:100%
26	Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттайгаар зохион байгуулах, цахимжуулах цахим	-	Цахимжуулсан үйлчилгээний тоо	2021	16 төрлийн үйлчилгээ	9 төрлийн үйлчилгээ шинээр цахимжина	Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах ажил явагдаж нийт 1614 иргэн цахим бүртгэлд хамрагдаад байгаа. Мөн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ цахимаар олгогдож байгаа. Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн

	үйлчилгээг иргэдэд сурталчлан таниулах				цахимжсан		бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид хамрагдах эрх үүссэн иргэдийн баримт бичгийн бүрдлийг ханган тухай бүр хувийн хэрэг нээн ХХҮГ-т түргэн шуурхай хүргүүлж, иргэдэд чирэгдэлгүй бүрэн олгоод байна. 2022 онд Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн материалыг хүлээн авч тухай бүрт нь цахим системд бүртгэн ХХҮГазарт хүргүүлэн ажиллаж байна. Нийгмийн халамжийн бүх үйлчилгээнүүд цахимжсан. Биелэлт:100%
Зорилт.1.23. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээш ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.							
27	Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлэн, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж иргэд, даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ.	-	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	2021	1995-2005 оны шимтгэл төлөлтийн тайланг цахимд оруулж, 2006 оноос хойш тайлан лавлагаа QR кодоор баталгаажсан.	Архивын цахим үйлчилгээг жигдрүүлж нийт үйлчлүүлэгчдийн 40 хувьд цахимаар үйлчилгээг үзүүлсэн байна.	Сумын хэмжээнд "https://www.facebook.com/esunzuil.daatgal" гэсэн цахим хаяг нээн иргэд даатгуулагчийг урьж одоогоор 320 гишүүнтэй болж өргөжин цахимаар мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цахим эмнэлгийн хуудас болон цахим дэвтрийн талаар мөн нийгмийн даатгалын аппликейшнийг суулгах заавар зөвлөмж өгч, суулгаж өгч ажиллаж байна. Биелэлт:100%

28	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлж хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	-	Нийгмийн даатгалын хамрагдалтын хувь	2021	Нийт малчдын НД-ын хамрагдалт 26% байна	2022 оны батлагдсан төсвийн хуваарийн дагуу төлөвлөгөөг биелүүлэх, малчдын хамрагдалтыг 27,5%-д хүргэх	Нийгмийн даатгалын сангийн орлого 530450.0 мян/төгрөгийг санд төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 130 хувь байна. Албан журмын орлого 473194.5 мян/төгрөг цуглуулж, төлөвлөгөөг 200 хувиар биелүүлсэн байна. Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого 95255.4 мян/төг, төлөвлөгөөний биелэлт 50 хувьтай байна. Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн дагуу даатгуулагчдын шимтгэл, хураамжийн орлого 121708.0 мян/төгрөг цуглуулж, орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлж ажиллалаа. Үүнээс хураамжийн орлого 21707.7 мян/төг, орлогын төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна. Шимтгэлийн орлого 100001.0 мян/төг, орлогын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.
							Биелэлт:100%
29	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг сурталчлах, эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2021	2	2	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар цахим хуудсуудад мэдээллийг байршуулж иргэдэд мэдээ мэдээллийг тогтмол хүргэж ажиллаж байна. Мөн эрүүл мэндийн даатгалыг цахимжуулан үйлчилгээг үзүүлж байна.
							Биелэлт:100%
Бүлгийн дүн:							88,4%
ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ							
Зорилго: Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, олон тулгуурт эдийн засаг бүхий өрсөлдөж чадвартай аймаг болно.							
САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ							
Зорилт.2.1 Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана							
30	Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллана.	-	Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хувиар	2021	90	Хуулийн хэрэгжилт 100%	Төсөвт байгууллагууд төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn тогтмол байршуулан улирал бүр мэдээллийг дээд шатны газарт илгээж, хяналт тавьж, Санхүү хяналт дотоод аудит улирал бүр хяналт шалгалт хийж хариуцлага тооцон ажиллаж байна.

							Биелэлт:100%
31	Төрийн сангийн үйл ажиллагааны портал цахим шилжилтийн хүрээнд эрхийн бүртгэлийн сан систем нэвтрүүлэх ажлын баазыг бүрдүүлж, цалингийн нэгдсэн системээс цалингийн гүйлгээг цахимжуулах	-	Хамрагдсан байгууллагын тоогоор	2021	-	193	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг тухай бүр нь шинэчлэн цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлыг төлөвлөж төрийн албан хаагчдийн цалинг олгож эхлэн ажиллаж байна. Хэрэгжилтэнд Сангийн яам, Төрийн сангийн хэлтэс хяналт тавин ажиллаж байна. Биелэлт:100%
Зорилт.2.2. Татварын бүр төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.							
32	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын баазыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.	-	Төсвийн орлого нэмэгдсэн байна.	2021	17,3 тэрбум	18,0 тэрбум	Татвар төлөгч иргэд болон Аж ахуй нэгж, төрийн болон хувийн хэвшлүүдэд татварын тухай хуулийн талаар сургалт, сурталчилгаа хийж мэдээлэл хүргүүлж байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт 15,829.460 буюу 101%, Аймагийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт 9,671.830 буюу 58%, Сумын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт 605,356.860 төгрөг буюу 200 хувьтай биелэгдээд байна. Биелэлт:90%
33	Иргэдэд татварын шинэчлэлийн талаар сургалт сурталчилгаа явуулна.	-	Сургалт сурталчилгаа явуулсан байна	2021	-	Малчдын МХТ-ын төлөлт 70%-аас дээш төлөлттэй иргэдийн НӨАТ ойлголт нэмэгдэж зөрчил багассан байна.	Татвар төлөгч иргэд болон Аж ахуй нэгж, төрийн болон хувийн хэвшлүүдэд татварын тухай хуулийн талаар сургалт, сурталчилгаа хийж мэдээлэл хүргүүлж байна. Мөн Малын хөлийн албан татварын тухай хууль, галт зэвсэгийн татварын талаарх гарын авлага бэлтгэн Эрээн, Хайрхан, Тахилганы багийн өрхүүдээр тойрон нийт 60 гаруй иргэнд хүргээд байна. Сумын малчдын зөвлөгөөн болон Тахилга, Мөнхбулаг, Хайрхан, Эрээний багуудын 6 удаагийн иргэдийн нийтийн хуралд татварын тухай хууль болон татвар төлөлтийн талаарх тайланг тайлагнаж мэдээ мэдээллийг хүргэн ажиллалаа. Биелэлт:90%

Зорилт.2.4.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоот компани, аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулж, хариуцлагыг тогтолцоог бий болгон аймгийн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэн орон нутгийн өмчийн менежментийг сайжруулна.							
34	Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл үнэлгээ, тайлан, орон нутгийн өмчийг данснаас хасах үйл ажиллагааг ил тод нээлттэй болгон өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.	-	Цахимжуулалтын хувиар	2021	32,6%	100%	Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэлд тусгах энэ онд улсын үзлэг тооллого зохион байгуулагдаж програмд оруулан нэгтгэж тайлан мэдээтэй тааруулж илгээж тайлагнасан байна. өмч эзэмшигчдийн гэрээг шинэчлэн хариуцуулан ажилласан. Биелэлт:90%
Зорилт.2.5. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, худалдан авах ажиллагаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан, цахим хэлбэрээр зохион байгуулна							
35	Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn шинэчлэлийг ашиглан тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг цахим системд бүртгэж хэвгинэ.	-	Цахимжуулалтын хувиар	2021	65%	100%	Сумын Засаг даргын захирамж, байгууллагын даргын тушаалуудад ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах үүднээс ашиг сонирхолгүй гэдгийг илэрхийлэх маягтыг бөглүүлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ аван ажиллаж байна. Мөн сумын Засаг даргын захирамж гарахад хянах журмыг батлан үйл ажиллагаанд ашиглан ажиллаж байна. Сумын 2022 оны худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хууль тогтоомжийн хүрээнд иргэдэд нээлттэй байдлаар www.shilendans.gov.mn сайтат байршуулан худалдан авах үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгжийг оролцох нөхцөл боломжоор ханган ажиллаж байна. Биелэлт:100%
36	Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагчид хөндлөнгийн төлөөллүүдийг, мэргэшүүлэх давтан сургах ажлыг зохион байгуулж, бүх шатны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж	-	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	2021	160 хүн	170 хүн	Төрийн албан хаагчдын худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх үүднээс Худалдан авах ажиллагаа явуулах АЗ сертификатгүй төрийн албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээнд АЗ сертификаттай болох заалтыг оруулж өгч ажиллан. 2022 оны жилийн эцсийн байдлаар сумын хэмжээнд АЗ сертификаттай 10 төрийн албан хаагч, 1 иргэн байна Биелэлт:90%

	хөндлөнгийн сайжруулна.	хяналтыг					
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ							
Зорилт.2.7. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос шилжүүлж, сүргийн зохистой бүтцийг хадгалах замаар түүхий эд бүтээгдэхүүний экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.							
37	Бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авна	50,0 сая	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор	2021	70 мянган га-д бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцсэн, орон нутгийн төсвөөр 3 худаг шинээр гарсан. 200 га бэлчээрийг чөлөөлсөн	Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготной 5,0 мянган га-д тэмцэх ажлыг зохион байгуулж, инженерийн хийцтэй гүн өрмийн 10 доошгүй худагшинээр гаргаж ажилласан байна	Нийт нутгийн хэмжээ 221,8 мянганга, Бэлчээрийн газар 214,5 мянганга, оготно тархсан талбай 176,9 мянган, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлсэн нийт талбайн хэмжээ 800 га, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлсэн талбайг нийт нутагтай харьцуулсан хувь 1,13 % оготно тархсан талбайн 1,4%. цаашид тэмцэх арга хэмжээ авах шаардлагатай талбайн хэмжээ 174370 га, ажлын техник үр дүн 87.2% сумын Засаг даргын ажлын дүн хэлэлцсэн хурлын тэмдэглэл дүгнэлтүүдийг үндэслэн мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн бэлчээрийн талбайг орон нутагт хүлээлгэн өгөөд байна. Эрээний дүгээр багийн малчин Л.Жамьяасүрэн нь өөрийн хөрөнгөөр 2 ширхэг гар худгийн гаргаад байна. Биелэлт:70%
38	Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлж тариаланчдыг бордоо техникийн дэмжлэгт, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг үрийн дэмжлэгт тус тус хамруулна.	-	Эргэлтийн талбайн нэмэгдсэн хэмжээ, дэмжлэг үзүүлсэн ААН тоогоор	2021	15,8 мянган га талбайд тариалалт	Эргэлтийн талбайг 100-аас доошгүй га-р нэмэгдүүлж, 20-аас доошгүй иргэн, ААН-г үр бордооны лэмжлэгт, 2-с	Мөн сумын тариаланч С.Эрдэнэхуяг, С.Нарандэлгэр нар нь өөрийн хөрөнгөөр тус тус 6 м2 хүлэмжид улаан, ногоон чинжүү, огурцы, сармис, сонгино зэргийг тариалж өөрийн хэрэгцээний хүнсний ногоогоо хураан авсан байна. Сумын хэмжээнд нийт 200 шуудай тэжээлийн үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан ав сумын хэмжээнд нийт 110 өрхөд тараан өгч ажилласан. 5 тн ногоон тэжээлийг хүрэн аваад байна. Мөн 400кг төмсний үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан авч 4 багийн иргэдэд тараан өгч ажилласан. Мөн аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар 40кг төл сонгины үр, сормис, байцаа, лууван, гар манжин, хүрэн манжингийн үрийн захиалга хүргүүлж

						доошгүй иргэн ААН-г техникийн дэмжлэгт хамруулсан байна.	үрийг авчран өрхүүдэд тараан тариалан дэмжих сангаас усжуулалтын системийг аван ажиллаад байна. Биелэлт:90%
39	Сумдад төмс хүнсний ногооны зоорийг шинээр барих, сэргээн засварлах, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.	-	Шинээр баригдсан зоорь, хүлэмжийн аж ахуйн шинээр нэмэгдсэн тоогоор	2021	92 зоорь, 182 хүлэмж	2-оос доошгүй зоорь, 3-аас доошгүй хүлэмжийн аж ахуйн шинээр нэмэгдсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөлтэй хамтран 30тн багтаамжтай хүнсний зоорийг 80,000,000 төгрөгний санхүүжилтээр барьж ажлын хэсэг хүлээн авч ажилласан. Биелэлт:100%
40	Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, хугацаа хэтэрсэн зээлийн өрийг барагдуулах арга хэмжээ зохион байгуулна.	-	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдлийн буурсан хувиар	2021	1156 иргэн, ААН 5,1 тэрбум зээлийн үлдэгдэлтэй	Хугацаа хэтэрсэн өр 350 ирэн, ААН 1,4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгааг 30 хувь бууруулна	Сум хөгжүүлэх сангийн зээлийн ашиглалт болон зээл төлөлтөд хяналт тавьж эргэн төлөлтийг сайжруулах эргэн төлөлтийн хуваарийг зээлдэгчид танилцуулж эргэн төлөлтийг эрчимжүүлэн ажиллаж байна. 2021 оны байдлаар 90 сая төгрөг сум хөгжүүлэх санд төлөврүүлсэн. Хугацаа хэтрэлтийг 20% хүртэл бууруулсан. 2022 оны хувьд Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 2022 оны 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 18-н иргэний төсөл "Төсөл сонгон шалгаруулах хороогоор" хэлэлцэгдсэнээс 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 10 иргэний төсөл тэнцэж үнэлгээний хороонд хүргүүлж ажиллаа. Хоршоо хөгжүүлэх сангаас 150 сая төгрөгийн санхүүжилтээр сумын тэргүүлэх чиглэлийн хүрээнд • Эсгий үйлдвэрлэл : 1 Хоршоо • Авто машин засвар үйлчилгээ: 1 ААН Хоршоо-1 • Бууз, банш, хэрчсэн гурилын цех :1 ААН ААН-3 • Зочид буудал, цайны газар: 1 ААН Иргэн-10

							• Сүү, Цагаан идээ боловсруулах : 4 иргэн • Мах, дайвар бүтээгдэхүүн: 1 иргэн • Гутал, монгол гутал үйлдвэрлэл: 2 иргэн • Хэрчсэн гурил үйлдвэрлэл: 1 иргэн • Оёдол: 1 иргэн • Нэхмэл шүр: 1 иргэн Төслийг сонгон шалгаруулж 1 хоршоо, 3 ААН, 10 иргэний төслийг дэмжин сум орон нутагтаа ажлын байр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлж ажиллалаа Биелэлт:100%
41	Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр сумдын тасгийн малын эмч, мэргэжилтэнгүүдийг хангана.	19,0 сая	Тоног төхөөрөмжөөр хангана	2021	МЭҮН 48 Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн улсын байцаагч нарт-2	Сумдын мал эмнэлгийн 19 эмя мэргэжилтнүүдийг таблетаар хангасан байна	Мал, амьтан тэдгээрийн гаралтай мах, түүхий эд, бүтээгдэхүүнд МЭАЦ-ийн үзлэг, шинжилгээ хийн ахуйн хэрэгцээнд хэрэглэх болон зах зээлд борлуулах малд гарал, үүслийн тодорхойлолтыг гаргаж, баталгаажуулан ажиллаа.Үүнд: 2022 оны 1-р сарын 1нь өдрөөс 11-р сарын 15 ны өдрийн хооронд тус сумаас нийт 422 гэрчилгээ гарсан байна. Амьд мал адуу-26 толгой, үхэр-13 толгой, хонь- 2676 толгой, ямаа-233 толгой нийт 2948 тоо толгой мал хүнсний зориулалтаар гарсан байна. Мах адууны мах 10616 кг, үхэрийн мах 9575 кг, хонины мах- 13460 кг, ямааны мах 770 кг нийт 34421 кг махыг мэдрэхүйн аргаар шинжилгээ хийн ахуйн хэрэгцээнд болон зах зээлд гарал үүслийн гэрчилгээ олгон нийлүүлсэн байна.
Зорилт.2.9. Эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой орон нутгийн дэд бүтцийг бий болгож, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.							
42	A0301, A0302 улсын чанартай авто замын дагуух Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт,	51,6 тэрбум	Ажлын гүйцэтгэлээр, Зураг төсөв	2021	-		Сумын төв дотор 2,7 км хатуу хучилттай авто зам хийх ажлын зургыг 18,0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр

	Хайрхандулаан сумдыг хатуу хучилттай авто замаар холбох, “Арвайхээр Хужирт, БАт-өлзий” “хужирт Төвхөн хийд Улаан цутгалан”, Арвайхээр Баянгол Сайхан овоо Цогт овоо”, Арвайхээр Гурван тэс Шивээхүрэн”, “Чойр Мандалговь Арвайхээр”, А302 улсын чанартай авто замаас Баянтээг баг хүртэлх 2022 километр авто замуудыг шинээр барих зураг төсвийг хийлгэж барьж эхлүүлнэ.		хийлгэсэн эсэх				хийлгээд байна. Дэлхийн банкны төслөөр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлээд байна. Биелэлт:50%
Бүлгийн дүн:							90%
ГУРАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
Зорилго: Нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд засаглалын хариуцлага, шударга ёсыг мөрдүүлж, цахим технологид тулгуурласан, иргэдэд тэгш боломж олгодог, оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлнэ.							
ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА							
Зорилт.3.1 Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтэй бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ.							
43	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчимд суурилж, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.	10,0 сая	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хамрагдсан албан хаагчдын тоо	2021	-	Нийт төрийн албан хаагчдын 20-оос доошгүй хувь хамрагдсан байна.	Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай” А/561 захирамжаар батлагдсан хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийг сургах, хөгжүүлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах ажлын гүйцэтгэл үр дүн, сахилга хариуцлага, ёс зүйг харгалзан дүгнэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын 2022 онд нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулан биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн чадахуйн зарчимын хүрээнд 2 албан хаагчийг туслах түшмэлээс дэс түшмэлийн ангилалд шилжүүлэн дэвшүүлэн ажиллуулж байна. Албан байгууллага тус бүр

							сургалтын бодлого дээр хэрхэн ажлыг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө болон дээд газраас зохиогдож буй сургалт семинарт идэвхитэй хамрагдсан үр дүнг тооцон ажиллаж байна. Сумын хэмжээнд бүх төрийн албан хаагчдийн Төрийн албаны зөвлөлийн Арга зүйн сургалт Мэргэжлийн бусад байгууллагын сургалтанд давхардсан тоогоор нийт 119 албан хаагчид хамрагдсан. Үүнээс 61 албан хаагчид төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан нийт 15 удаагийн сургалтанд тавтамжтай тоогоор, мэргэжлийн бусад байгууллагын сургалтанд нийт 63 албан хаагчид хамрагдаж ажилласан байна. Сумын хэмжээнд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 20 удаагийн цахим сургалт, Удирдах ажилтаны сургалт, Төлөөлөгч нарыг чадавхжуулах боловсрол олгох сургалт, Орон нутгийн соёлын ажилтануудын мэргэжил дээшлүүлэх сургалт, "Хоол зүйн" сургалт, "Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсвийн хэлэлцүүлэг" сургалт, "Улсын тооллогын бүртгэл", "Хүүхэд хамгааллын талаарх сургалт", Малчдын зөвлөгөөн, сургалт сурталчилгаа, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт, Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системтэй ажиллах талаарх сургалт, Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй, Эрүүл мэндийн даатгалын цахим системийн шинэчлэл, E hospital-ийн заавар сургалт, Ногоон байгууламжийг нэмэглүүлэх нь зэрэг дотоодын болон дээд шатны байгууллагуудаас зохион байгуулагдсан сургалтын үйл ажиллагаанд 100% хамрагдан ажиллаж байна. Биелэлт:100%
44	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, цогц чадамж, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон	-	Ёс зүйн зөрчлийн тоо үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	2021	-	Ажлын гүйцэтгэл, үр дүн, ёс зүй хариуцлагын үзүүлэлтээ	Төрийн албан хаагчдыг ажлын гүйцэтгэл, үр дүн, ёс зүй хариуцлагын үзүүлэлтээр үнэлэн үр дүнгийн урамшуулал болон гүйцэтгэлийн урамшууллыг олгож ажиллаж байна. Төрийн албан хаагчдыг 2022 оны дөрөвдүгээр улиралын байдлаар нийт өссөн дүнгээр Засаг даргын Тамгын газрын 11 албан хаагчдын 4655237 хагас, бүтэн жилийн үр дүнгийн гүйцэтгэлийн

	дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ.					р үнэлсэн байна.	төлөвлөгөөний урамшууллыг олгоод байна. Сөбб-ийн багууллага нь нийт 14 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг. Мөн 2022 онд нийт 14 хүний 7879570 төгрөгний үр дүнгийн урамшууллыг олгож ажилласан байна. Соёлын төвийн ажилчид албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллаж ажлын чанар үр дүн өндөр байх тал дээр тодорхой шаардлагууд тавьж хангаж ажиллаж байна. Мөн 2022 онд нийт 7 албан хаагчийн 2386922 төгрөгний үр дүнгийн урамшуулал олгоод байна. Эрүүл мэндийн төвийн хувьд албан хаагчиддаа ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллаж байгаа бөгөөд 2022 оны хувьд нийт 47 албан хаагчдад 18896287 төгрөгний үр дүнгийн урамшууллыг олгож ажилласан байна. Ерөнхий боловсролын сургууль нь багш ажилчдын нийгмийн баталгааг хангаж ажиллаж байгаа бөгөөд нийт 51 албан хаагчдын 24308790 улирлын үр дүнгийн урамшууллыг олгож ажлаад байна. Биелэлт:100%
45	Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх багууллагад ил тод нээлттэй болгоно.	-	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын зөрчлийн үзүүлэлтийг бууруулсан байдал (тоо)	2021	-	Төрийн захиргааны байгууллагын тоогоор	Байгууллага тус бүр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актууд, дүрэм журам болон бусад тогтоол шийдвэрүүдийн нэгдсэн цахим сантай болж, шинээр гарсан тушаал шийдвэрүүдийг цаг хугацаанд нь албан хаагчиддаа танилцуулан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна. Төрийн албан хаагчдийн сахилга хариуцлага дэг журмыг чангатгах үүднээс албан хаагчдад байгууллагын дотоод журмыг дахин танилцуулж гарын үсгийн баталгааг авч мөрдлөг болгон ажиллаж байна. Албан байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн гишүүдэд 2022 онд Засаг даргын Тамгын газар 1 удаа, Эрүүл мэндийн төв 6, Цэцэрлэг 2, нийт 9 удаа нээлттэй хэлэлцүүлэг, сургалтын арга хэмжээ зохион байгуулж ажиллаж байна. Мөн Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сахилга хариуцлага, ёс зүйн зөрчилгүй ажиллах талаар ажлыг тусган хэрэгжилтийг нь тооцон ажиллаж байна. Мөн төрийн албан хаагч бүрээр Төрийн албаны манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, төрийн хууль ёсыг чанд

							сахин аймаг орон нутгийнхаа хөгжлийн төлөө эрдэм чадлаа зориулж, өөрийн болон байгууллага, хамт олныхоо нэр төр, соёлч байдлыг эрхэмлэн иргэдийг ялгаварлахгүйгээр ижил тэгш, зөв шударга харьцаж, ажлын цагийг цалгардуулж хийдүүлэхгүй, бүтээмжээ нэмэгдүүлж, аливаа хууль бус дарамт шахалтад автахгүй, үйлдэхгүй, албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байхаа илэрхийлж баталгаа гаргуулан аваад байна. Мөн ёс зүй болон сахилгын зөрчил илэрсэн байдал нь Есөнзүйл сумын хэмжээнд 2022 онд 2 албан хаагч сахилгын зөрчил гарган хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын дотоод журмаар сахилгын хариуцлага тооцуулсан байна. Мөн албан байгууллага, албан хаагчдын өргөдөл гомдол шийдвэрлэлтэнд хяналт тавин тайлан мэдээг Төрийн захиргаа удирдлагын хэлтэст улирал тутам хугацаанд нь хүргүүлж ажиллаж байна. Биелэлт:100%
46	Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавьж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	-	Зөрчилтэй шийдвэрийн тоо буурсан	2021	-	Зөрчилтэй шийдвэрийн тоог 70 хувиар бууруулах	Сумын Засаг дарга 2022 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар боловсон хүчний чиглэлээр нийт 17 захирамж, Засаг даргын Тамгын газрын дарга боловсон хүчний чиглэлээр 21 тушаал гаргасан байна. Захирамж тушаал гарах тухайн цаг бүрт үндэслэл хэсэг дэх хууль, тогтоол, дүрэм журмыг албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамын дагуу хянах үйл ажиллагааг тогтмол явуулж байна. Биелэлт:100%
Зорилт.3.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, зардал хэмнэх тогтолцоонд шилжүүлж, төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулна.							
47	Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж албан хэрэг хөтлөлт, албан бичгийг цахимаар солилцох системийг нэвтрүүлэн, сум, багийн иргэдэд e-mongolia	10,0 сая	Систем ашиглалтын хувь Сургалт өдөрлөгт	2021	-	Программ ашиглалтын хувь 80	E-mongolia цахим систем болон иргэдэд шууд хүрч үйлчлэх нийт 90 үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар e-mongolia цахим системээс нийт 70 иргэнд, 100 гаруй иргэнд хууль эрх зүй болон шүүхийн талаарх мэдээ мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажилласан байна. Мөн хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр нийт 10 гаруй сэдвийн хүрээнд

	болон бусад цахим үйлчилгээг сурталчлан таниулах сургалт, өдөрлөг зохион байгуулах		оролцсон иргэдийн тоо				цахим хаягаар мэдээллийг хүргэн 1500 иргэний хандалт аван ажиллаж байна. Мөн 8 сэдвийн хүрээнд гарын авлага боловсруулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Мөн Суманд эд хөрөнгийн бүртгэлийн улсын бүртгэлийн эрх 2022 оны 02 дугаар сараас эхлэн нээгдэж Барьцаалбарын гэрээний бүртгэл 2, худалдах худалдан авах гэрээний бүртгэл 12, өөрт ноогдох хэсгээ бусдад бэлэглэх гэрээ 7, Барьцаалбар лдуусгавар болгох бүртгэл 21, Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 2, Эд хөрөнгийн үнэ, хэмжээ гүйцэтгэл өөрчлөгдөх 14, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 2, нийт 62 бүртгэлийг жилийн эцсийн байдлаар хийгээд байна. Суманд ЭХЭУБүртгэлийн үйлчилгээ нээгдснээр иргэд тус үйлчилгээг газар дээрээс нь түргэн шуурхай авч чадаж байна. Биелэлт:90%
48	Төрийн байгууллагуудын засвар шинэчлэлт, албаны автомашин компьютер техник хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	100,0 сая	Ашиглалтад орсон барилга, техник хэрэгслэлийн хангалтын хувь	2021	-	Шийдвэрийн тоогоор	Тахилга, Мөнхбулаг, Хайрхан, Эрээний багуудын Засаг дарга нарыг унааны 50 хувийг буюу 6,000,000 төгрөгөөр хөнгөлөн унаагаар хангаж мөн зөөврийн компьютер, бинзэн шатахууныг нэмэгдүүлэн хамтран ажиллах боломж нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс 4 зөөврийн компьютер, 1 олон үйлдэлт принтерээр шинээр ханган ажиллаж байна. Биелэлт:100%
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ							
ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛТОЙ ИРГЭН, ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАСАН НИЙГЭМ							
Зорилт.3.3 Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүдэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна							
49	Сумдад эрх зүйн танхимыг байгуулж тэдгээрт түшиглэн танхимаар эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт сурталчилгаа зохион	8,5 сая	Сумдад байгуулагдсан эрх зүйн танхимын тоогоор	2021	Эрх зүйн хөтчүүдийг цахимаар ажиллах	Эрх зүйн танхим сумдад байгуулагдсан тоо,	Суманд эрх зүйн танхимыг бий олгон эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч сургалт сурталчилгааг зохион байгуулж ажиллаж байна. Үүнд:

	байгуулах хүртээмжийг нэмэгдүүлнэ.				чадавхыг сайжруулсан	эрх зүйн хөтөч ажиллах боломж нөхцөл бүрдсэн байх	1. Имонголиа цахим системээс лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт зэрэг нийт 90 цахим үйлчилгээ 2. Албан байгууллага болон иргэдэд үзүүлэх хуулийн зөвлөгөө 3. Иргэдэд хүрч үйлчлэх эрх зүйн булан 4. Албан байгууллага иргэдэд хүрч үйлчлэх сургалт сурталчилгаа 5. Иргэдэд хүрч үйлчлэх шүүхийн туслалцаа мэдээллээр хангах 6. Иргэдэд ГХУС ажлын талаарх мэдээ мэдээлэл зэрэг нийт 95 үйлчилгээг үзүүлж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар emongolia цахим системээс нийт 70 иргэнд, 100 гаруй иргэнд хууль эрх зүй болон шүүхийн талаарх мэдээ мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажилласан байна. Мөн хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр нийт 10 гаруй сэдвийн хүрээнд цахим хаягаар мэдээллийг хүргэн 1500 иргэний хандалт аван ажиллаж байна. Мөн 8 сэдвийн хүрээнд гарын авлага боловсруулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Биелэлт:90%
50	Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээнд орон нутгийн иргэд, олон нийт, залуучууд, зорилтот бүлгийн оролцоог ханган хөгжлийн бэрхшээлтэй болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.	3,2 сая	Сургалтын тоогоор	2021	15 сургалт арга хэмжээ зохион байгуулсан	Тухай бүр зохион байгуулсан арга хэмжээний тоо	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль эрх зүй, тогтоол шийдвэрийг сумын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. “Жендерийн тэгш байдлыг хангах тухай” хууль болон жендэртэй холбоотой мэдээ мэдээлэл, видео, шторкуудыг сумын цахим хуудас, байгууллагын цахим хуудаст байршуулан мэдээллийг хүргэж байна. 2021.12.24 №2/613 тайлан ирүүлэх тухай албан тоотын дагуу Хүйсийн тэнцвэрт байдлын тайлан, Б-ЖЭТБ-4 тайлан, Жендэр-өв дэд хөтөлбөр”ийн биелэлтийг холбогдох дээд байгууллагад хугацаанд нь хүргэж ажиллаж байна. Биелэлт:70%
АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ							

Зорилт.3.4. Олон нийтийг соён гэгээрүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

51	Авлига ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх аян нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.	15,0 сая	Зөрчлийн буурсан үзүүлэлтээр	2021	Байгууллага урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй болсон	Нөлөөллийн арга хэмжээний үр дүнг тооцон ашиг сонирхлын зөрчлийн тоо буурсан үзүүлэлт	АТҮХөтөлбөрийн суманд хэрэгжүүлэн ажиллах 2022 оны ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар баталгаажуулан албан байгууллага бүрт төлөвлөгөөг хүргүүлэн биелэлтийг нь жил бүр тооцон ажиллаж байна. Мөн төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг жил бүр тооцон ажиллалаа. Мөн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцон ажилласны үр дүнд авлига, ашиг сонирхлын зөрчил дутагдал илрээгүй байна.
Биелэлт:100%							

ХҮНИЙ ЭРХ, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ

Зорилт.3.5 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ хэрэгжүүлж, иргэдийн иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.

52	Олон нийтийн цагдаагийн урамшуулал болон хувцас хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлнэ	-	Урамшуулал хувцас хэрэгслээр хангагдсан эсэх	2021	-	Урамшуулал хувцас хэрэгслээр хангагдсан байна.	Есөнзүйл суманд 2019 оноос эхлэн Олон нийтийн цагдаагийн орон тоог бий болгон ажиллуулж байна. Олон нийтийн цагдаагийн ажиллах нөхцөл боломжийг нээг 1 жилийн хувцас хэрэглэл болон 500000 төгрөгөөр жилийн 5,760,000 цалинжуулан ажиллаж байна.
Биелэлт:100%							

БАТЛАН ХАМГААЛАХ

Зорилт.3.7 Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

53	Цэргийн дайчилгааны даалгаврын дагуу сумдын цэргийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангана.	1,5 сая	Төлөвлөгөө даалгавар боловсруулсан эсэх дагуу аймгийн төлөвлөгөө	2021	Аймгийн цэргийн дайчилгааны даалгаврын дагуу аймгийн	2022 онд 19 сумын цэргийн дайчилгааны даалгаврын дагуу	Есөнзүйл сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг аймаг, сумын засаг даргаар баталгаажуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Суманд маш нууц, нууцын зэрэглэлтэй 24 албан бичгийг төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хүрээнд хадгалж, биелэлтийг нь ханган ажиллаж байна. Сумын дайчилгааны
----	---	---------	--	------	--	--	--

			боловсруулж батлуулсан		төлөвлөгө ө боловсруу лж батлуулса н	аймгийн төлөвлөгөө боловсруу лж батлуулсан	төлөвлөгөөг хийж хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөг боловсруулах шатандаа байна. Биелэлт:100%
Бүлгийн дүн:							95,4%
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧИН							
Зорилго: Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж байгалийн баялгийг зүй зохистой ашиглан, нөхөн сэргээж, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.							
НОГООН ХӨГЖИЛ							
Зорилт.4.1. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.							
54	Булаг шанд, рашааны эхийг хамгаалах	14,0 сая	Хашиж хамгаалсан булгийн эхийн тоо хэмжээ	2021	336 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалсан	10-аас доошгүй булгийн эхийг хашиж хамгаална	Есөнзүйл сумын уугуул "Царгаст хайрхан" ХХК-ны захирал Цэдэнбазарын Өлзийбаярын санаачилгаар сумын ширгэсэн Тарвагатайн булаг, Тогоотын булгийн эхийг хамгаалж нийт 400 ширхэг мод тарьж, гадуур нь хашаалж хамгааллаа. Булгийн эхэд мод тарьсанаар халзарсан хөрсний эко систем сэргэж, цэвдэгшил нь бий болж ширгэсэн хоёр булаг маань 1-2 жилийн дотор ундаргатай болох юм. Тус хоёр булгын хараа хяналт, тавин ажиллаж байна. Ундны усны сорьц дээжийн шинжилгээг сумын эмнэлэгийн байгууллагаар ариутгуулж зохих журмын дагуу саванд хийж аймгийн Мэргэжлийн хяналтын лабораторид шинжилүүлсэн. Хариуг холбогдох газарт хүргүүлсэн. Юнитель группийн хөрөнгө оруулалтаар зэрлэг ан амьтдын өсөх, байрших нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор Задгайт, Ганьд орчимд бага хэмжээний хөв цөөрөм байгуулан ажиллалаа. Биелэлт:90%
Зорилт.4.2 Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.							

55	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжих, сумдыг дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх боломжоор хангах	140,0 сая	Хоёрдогч түүхий эд нягтруулах төхөөрөмжөөр хангагдсан байдал	2021	2021 онд 4 суманд хоёрдогч түүхий эд нягтруулж пресслэх төхөөрөмж нийлүүлсэн	Зарим сумдад хоёрдогч түүхий эд нягтруулж, пресслэх төхөөрөмж нийлүүлсэн байна.	Хог тээврийн машиныг 2020 онд худалдан авч 2021 онд хог ачих өдөр болон үнэ тарифын хэмжээг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулан хог ачааллах ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна. Сумын бүх нийтийн цэвэрлэгээг жил болгон хавар болон намрын улиралд тогтмол зохион байгуулж ажиллаж байна. 2022 оны хувьд 04 дүгээр сарын 01,02-ний өдрүүдэд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгууллаа. Сумын төвийн Баруун, Зүүн голуудын ойр орчмын голдиролууд, Далангийн нуураас төв засмал дагуух хог хаягдал, сэг зэмийг цэвэрлэж нэгдсэн хогын цэгт төвлрүүлээ. Засмал дагуу цэвэрлэсэн хог 5 тн, Даянгийн голоос хиймэл нуур хүртэл 11 тн хог хаягдал, Асгана булгаас уулзвар хүртэл 10 тн хог хаягдал, малын сэг зэмийг зөөж нэгдсэн хогийн цэгт дарж булшлах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд нэвтрүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх зориулалтын техник болох Пресслэгч машиныг худалдан аваад байна. Энэхүү төхөөрөмжийн тусаар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломж бүрдээд байна. Биелэлт:90%
56	Төрийн үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хууль, дүрэм, журам, стандарт, тэрбум модыг тарих ажлыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт хэм хэмжээг мөрдүүлэн байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	10,0 сая	Байгаль орчны сургалт сурталчилгаа болон сургалтад хамрагдсан иргэдийн тоо хэмжээгээр	2021	-	Байгаль орчны хууль тогтоомж, дүрэм журмыг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллах	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/76 дугаар тушаалуудын хүрээнд суманд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж нутгийн 250-аад айл өрх давхардсан тоогоор 354 иргэдэд хууль бус бугийн эвэр түүх, ой хээрийн түймрын урьдчилан сэргийлэх 300 гаруй брошур гарын авлага бэлтгэн тараан иргэдэд байгаль хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэдээ мэдээлэл өгөн ажилласан. Иргэдийн байгаль орчныг хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор багийн иргэдийн нийтийн хуралд орчны бохирдол, ан амьтныг хайрлан хамгаалах талаар мэдээлэл хийж байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Биелэлт:90%

Бүлгийн дүн:						90	
ТАВ."КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
Зорилт.5.1 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж% үйлчилгээний хариуц арга хэмжээний бэлэн байдлыг хангана.							
57	Коронавируст халдварын батлагдсан тохиолдолд хэрэглэгдэх вирусийн эсрэг эм, сонгомол антибиотик, үрэвслийн эсрэг эм, тарианы нөөцийг бүрдүүлнэ.	-	Вирусын эсрэг эмийн хангалтын хувь, АБ хангалтын хувь, Шингэн бэлдмэлийн хангалтын хувь	2021	70,85,70	80,90,70	Суманд 2022 оны 01 сарын 11-ээс 2022 оны 12 сарын 03 хүртэлх хугацаанд нийт 64 коронавирусын батлагдсан тохиолдол бүртгэгдсэн. ЭМТ нь коронавирус халдварын тархалтын үед бэлэн байдлыг ханган ажиллаж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслэлийн 2 сарын нөөцтэй. Нэг удаагийн хамгаалах хувцасны нөөц: • Юүдэнтэй комбинзон 150 ширхэг • Халад малгай тус бүр 500 ширхэг • Амны хаалт- 2500 ширхэг • N95 маск 650 ширхэг • Гутлын гадуурх углааш 500 ширхэг • Бээлий 2500 ширхэг • Нүдний шил 150 ширхэг Нэн шаардлагатай эм тарианы нөөц: • Вирусын эсрэг эм • Антибиотик эм • Шингэн сэлбэх зэрэг шаардлагатай эмийн 2 сарын хэрэглээний нөөцтэй. \15 сая 600 мянган төгрөг\ Мөн коронавирусын хамар залгиурын түргэвчилсэн тест, цусны тест, пср-ийн сорьцийн хэрэглээг 2 сарын \2 сая 250 мянган төгрөг\ нөөцийг ханган ажилласан байна. Биелэлт:100%
58	Цар тахлын үед ажиллах тусгаарлан эмчлэх болон тусгаарлан ажиглах байрыг томилгоожуулж бэлэн байдлыг хангана	-	Тусгаарлах эмнэлгийн орны тоо, тусгаарлан ажиглах байрны орны тоо	2021	Байхгүй	Эхлүүлсэн байна	Сумын засаг даргын тушаал, эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 01 сарын 14-ний тушаалын 1 дүгээр хавсралтаар коронавирусын халдварын үед тусгаарлах эмнэлгийн ор, 2 дугаар хавсралтаар ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 3 дугаар хавсралтаар тусгаарлан ажиллах байрыг зохион байгуулж ажилласан. Тусгаарлах эмнэлэг улаан, шар, ногоон гурван бүстэй. Голомтонд ажиллаж буй эмч, эмнэлгийн

							мэргэжилтэнийг байрлуулах өрөө тасалгаатай. Үйлчлүүлэгчийн өрөөнд: 1. Гар угаалтуур 2. Шалны хувин 3. Хоёр ээлжийн шалны алчуур 4. Түрүүл мод 5. Эд аж ахуй арчих тоосны алчуур тус бүрдээ нэг нэг 6. Гар халдваргүйжүүлэх саннитол 7. Гарын саван, ор, цагаан хэрэгсэл 8. Шүүгээ 9. Ус буцалгагч халуун саваар хангаж тохижуулалт хийсэн. Биелэлт:100%
Зорилт.5.2 Цар тахлын үед боловсролын үйлчилгээг тасралтгүй тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.							
59	Цар тахлын үед сургалтын байгууллагын орчинд халдваргүйтгэл хийж, багш ажилчдыг халдвар хамгааллын хувцас хэрэгслээр хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	-	Халдваргүйтгэл хийж хэвшсэн байгууллагын эзлэх хувиар	2021	70	120	Ариутгал халдваргүйтгэлийн бодисыг ЭМС-н 2019 оны 11 сарын 29-ний өдрийн 537 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу төсөвт байгууллага, аж ахиу нэгжийн 90,400м2 талбайг Жавелин-3600ширхэг, Хлорын шохой 50кг-ийг ашиглан ариутгал халдваргүйтгэл хийсэн байна. Тусгаарлах эмнэлгийн эрчимт эмчилгээний өрөөнд нэг үйлдэлтэй ор, зүрхний цахилгаан бичлэг, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, дуслын болон судасны шахуурга, цэр соруулагч, монитор, 4 литрийн хүчилтөрөгчийн баллоноор тохижуулан ажиллаад байна. Биелэлт:90%
60	Сургууль, цэцэрлэг бүр цахим теле хичээл бэлтгэн, технологийн сан бүрдүүлж гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл сургалтыг тасралтгүй үргэлжлүүлж, танхимын болон танхимын бус хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дамжин, тэгш хүртээмжтэй, чанартай	-	Цахим, теле хичээлийн тоо, технологийн сан бүрдүүлсэн эсэх	2021	70	120	Тус сургуулийн мэргэжлийн багш нар нь өөрсдийн бэлтгэсэн цахим хичээлийн сантай бөгөөд теле хичээл болон бусад мэргэжлийн багш нарын бэлтгэсэн цахим хичээлүүдийн санг бүрдүүлж гэнэтийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд хүүхэд Цар тахлын үед 4 бүлгийн эцэг эх асран хамгаалагчидтай Бүлгийн групп чат нааж тухайн группээрээ цахим хичээлүүдийг бэлтгэн тавих, үлгэр, шүлэгийг нь цахим болгож хүүхдэд сонирхолтой эцэг, эхчүүдэд хүүхдэд

зохион байгуулж хоцрогдол арилгаж төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.						заахад дөхөмтэй байхаар бэлтгэж өгч байсан. Мөн боломжтой үед нь гэрээр даалгавар боловсруулж тарааж өгч үр дүнг тооцож ажилласан. Нийт 2 удаагийн давтамжтай 70 гаруй хүүхдэд дасгал ажлын ном, дуу шүлэг, дүрслэх урлах урлан бүтээх нийт 230 гаруй ном бэлтгэж өгсөн. Цахим хичээлээс гадна дасгал даалгавар өгч биеэр хийлгэх нь үр дүнтэй байсан. Биелэлт: 90%
Бүлгийн дүн:						95%
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ:						91,4%

ХЯНАСАН: /
СУМЫН ЗАСАГ ДАРГА ~~С.О.~~ Т.ВАТ-ӨЛЗИЙ
ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Т.МӨНХЗУЛ